МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Хог хаягдлын тухай хууль / шинэчилсэн найруулга / товч танилцуулга

2017-09-20

Эрх зүйн орчин, бодлого, стратеги

Хог хаягдлын тухай хууль
/2012 он/



Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга
/2017 он /

Олон улсын гэрээ конвенц:

- **Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенцид Монгол Улс 1996 онд нэгдэн орсон.**

Хог хаягдлын тухай хуульд заасан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө, холбогдох журам, жагсаалт, аргачлал

- **Эрхзүйн 5 актууд мөрдөгдөж байна.**

ХУУЛИЙН ЗОРИЛТ

- **Хог хаягдлаас хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх,**

- **хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулж, байгалийн нөөц баялагийг хэмнэх,**

иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшилүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох

- **аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.**

Хог хаягдлын тухай хууль шинэчилсэн найруулга

ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ:

ЭНГИЙН ХОГ ХАЯГДАЛ	• ХАТУУ
Аюултай Хог Хаягдал (цацраг идэвхтээс бусад)	• ХИЙ • ШИНГЭН • ХАТУУ



Хог хаягдлын тухай хууль шинэчилсэн найруулга

БҮТЭЦ: 8 бүлэг, 43 зүйлтэй.

I БҮЛЭГ.	• НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
II БҮЛЭГ.	• ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ, ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ
III. БҮЛЭГ.	• ХОГ ХАЯГДЛЫН МЭДЭЭЛЛИЙН САН, МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ, ХЯНАЛТ
IV. БҮЛЭГ.	• ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, СЭРГЭЭН АШИГЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ
V. БҮЛЭГ.	• АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ САВЛАХ, ТҮР ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ, ЦУГЛУУЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ
VI. БҮЛЭГ.	• ХОГ ХАЯГДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ
VII.БҮЛЭГ	• ХОГ ХАЯГДЛЫН БОЛОВСРОЛ
VIII.БҮЛЭГ	• БУСАД ЗҮЙЛ

Хог хаягдлын тухай хууль шинэчилсэн найруулга

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх

Дараах журам, жагсаалт батлах:

- ❑Аюултай хог хаягдлын зөвшөөрөл олгох журам
- ❑Мэдээллийн сан, мэдээлэл төвлөрүүлэх журам
- ❑ Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийг батлах
- ❑ Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон бараа импортлогч хариуцах зарим бараа бүтээгдэхүүний жагсаалтыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах

Дараах дүрэм, аргачлал, шаардлагыг батлах:

- ❑хог хаягдлын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм
- ❑ энгийн хог хаягдлын норматив тогтоох аргачлал
- ❑ хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар
- ❑энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага

❑Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох

Хог хаягдлын тухай хууль шинэчилсэн найруулга

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

Дараах маягтыг батлах:

а/ аюултай хог хаягдлын дагалдах бичгийн маягт;

б/ аюултай хог хаягдлын үүсгэгч болон цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх маягт;
в/ энгийн хог хаягдал цуглуулах, ангилах,тээвэрлэх, дахин боловсруулах, эргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх маягт;

г/ аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааны тайлангийн маягт;
д/ энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатааж устгах, булшлах үйл ажиллагааны тайлангийн маяг

Дараах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэх:

а/ аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх;
б/энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх;

Дахин боловсруулах боломжтой түүхий эдээр болон дахивар нөөцөөр үйлдвэрлэсэн, бүтээгдэхүүний шошгон дээр байрлуулах тэмдгийг стандартаар батлуулах

Хог хаягдлын тухай хууль шинэчилсэн найруулга

- зам тээвэр, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрчим хүчний зохицуулах хороо

Хог хаягдлын тухай хууль шинэчилсэн найруулга

Нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрх

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдын хурал

- Хог хаягдлын менежментийг сайжруулах **дэд хөтөлбөр** батлах
- Хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, булшлах, устгах **журам** батлах
- Урамшуулал олгох **журам** батлах
- Энгийн хог хаягдлыг **цэвэрлэх, булшлах** зардлын нэгж **тарифыг** батлах

Сум ,дүүргийн иргэдийн Төлөөлөгчдын хурал

- ***тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох.***
- ***энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг батлах;***

Хог хаягдлын тухай хууль шинэчилсэн найруулга

Нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрх

Аймаг, нийслэлийн Засаг дарга:

- Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон устгах, булшлах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэх **зөвшөөрөл олгох журам** батлах, журмын дагуу **зөвшөөрөл олгох**
- Энгийн болон аюултай хог хаягдлын үйл ажиллагаанд **хяналт** тавих
- Төрийн өмч, олон улсын зээл тусламжийн хөрөнгөөр хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, булшлах, устгах байгууламжийн операторыг **сонгон шалгаруулж, гэрээ байгуулах**
- Хог хаягдлын **олон нийтийн байцаагч** ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох **журмыг** батлах
- Нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах **зардлыг** шийдвэрлэх

Сум, дүүргийн засаг дарга:

- Хог хаягдлыг **цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх** үйл ажиллагаа эрхлэгчийг **сонгон шалгаруулж, гэрээ байгуулах**
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг орлогоор төвлөрсөн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулна.
  - **хог хаягдал цуглуулах,**
  - **тээвэрлэх,**
  - **булшлах,**
  - хог хаягдлын үйлчилгээний хураамж төвлөрүүлсний **шимтгэл**
- Хог хаягдлын талаарх сургалт, сурталчилгаа зохион байгуулах
- Олон нийтийн байцаагчийн урамшууллыг **төсөвт** тусгаж, ажиллуулах

Хог хаягдлын тухай хууль шинэчилсэн найруулга

Хориглох үйл ажиллагаа	Хүлээлгэх хариуцлага
Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолой руу хаях	Иргэнийг 50 000 төг, хуулийн этгээдийг 200 000 төг торгох
нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях;	Иргэнийг 50 000 төг, хуулийн этгээдийг 200 000 төг
хог хаягдлыг ил задгай шатаах	Иргэнийг 50 000 төг, хуулийн этгээд 400 000 төг торгох
гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах;	Иргэнийг 50 000 төг, хуулийн этгээд 200 000 төг торгох
хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;	Иргэнийг 50 000 төг, хуулийн этгээд 400 000 төг торгох
аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;	Иргэнийг 50 000 төг, хуулийн этгээд 400 000 төг торгох
нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа -байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх	Иргэнийг 50 000 төг, хуулийн этгээд 500 000 төг торгох

Анхаарал хандуулсанд баярлалаа!



ЦЭВЭР САЙХАН ОРЧНЫГ ХАМТДАА БҮТЭЭЦГЭЭЕ.

Хог хаягдлын тухай хууль зөрчих

Хог хаягдлыг зориулалтын цэгээс бусад газарт хаясан

Хүн 30 нэгж, Хуулийн этгээд 300 нэгж

Хог хаягдлыг ил задгай шатаасан

Хүн 50 нэгж, Хуулийн этгээд 500 нэгж

Хүн амын төвлөрсөн суурьшлын бүс, усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүс, ашигт малтмалын нөөц тогтоогдсон газарт зөвшөөрөлгүйгээр, эсхүл хуулиар хориглосон бусад газарт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулсан

Хүн 300 нэгж, Хуулийн этгээд 3000 нэгж

Хууль, дүрэм, журам, стандартад заасан хэмжээ, шаардлагад нийцээгүй сав, баглаа боодлыг: үйлдвэрлэсэн, импортолсон, удалдаа, үйлчилгээнд хэрэглэсэн

Хүн 300 нэгж, Хуулийн этгээд 3000 нэгж

Хог хаягдлыг: ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах журам зөрчсөн

Хүн 100 нэгж, Хуулийн этгээд 1000 нэгж

Аюултай хог хаягдлыг: цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, хадгалахад эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авахаар заасныг зөрчсөн

Хүн 300 нэгж, Хуулийн этгээд 3000 нэгж

Барилгын хог хаягдлыг: Тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах журам зөрчсөн

Хуулийн этгээд 3000 нэгж

Эмнэлгийн аюултай хог хаягдлыг: цуглуулах, тээвэрлэх, түр хадгалах, устгах журам зөрсөн

Хуулийн этгээд 3000 нэгж

Аюултай хог хаягдлын өмчлөгч нь өмчлөх эрхээ шилжүүлсэн талаар хуульд заасан мэдэгдэх үүргээ биелүүлээгүй

Хүн 100 нэгж ,Хуулийн этгээд 1000 нэгж